

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.06.03

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

НЭГ. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/1712 тоот тушаалаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулсан.

Ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-т нийцүүлэн боловсруулж, 6 дэд ажлын хүрээнд нийт 112 ажил хийхээр төлөвлөсөн.

2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар дараах тоон мэдээллийг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Үүнд:

Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 1/395 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу сонгуулийн насны иргэдийн тоог 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар аймаг, нийслэл, сум, дүүрэг баг, хороо тус бүрээр гаргаж хүргүүлсэн. /сонгуулийн насны нийт 2.226.371 иргэн/

СЕХ-ны 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3/38 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар аймаг, нийслэл, сум, дүүрэг баг, хороо тус бүрээр гаргаж хүргүүлсэн. /сонгуулийн насны нийт 2.230.101 иргэн/

Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтэст 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар нийт сонгогчийн тоог аймаг, дүүрэг, баг, хороо тус бүрээр гаргаж хүргүүлсэн. /сонгуулийн насны 2,230,607 иргэн/

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд зөөврийн компьютер, принтер тус бүр нь 3000 ширхэг болон бусад дагалдах хэрэгслийг худалдан авч, сонгогчийн бүртгэлийн техник, тоног төхөөрөмжид техникийн үзлэг, тооллого хийх бэлэн байдлыг хангах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.17 дахь хэсэгт “Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн нэг сантай байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ” гэж, 20.22 дахь хэсэг “Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ” гэсэн нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор УБЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгуулсан “МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн санал авах өдөр нэгдсэн сангаас сонгогчийг таньж бүртгэл программ хангамж, гадаад улсад санал өгөх сонгуулийн эрх бүхий иргэнийг таньж бүртгэх программ хангамжийг хөгжүүлэх, бодлогын даалгавар боловсруулах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсэг”-ийг холбогдох газруудын төлөөллийг оролцуулан байгуулсан.

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах программ хангамжийг боловсруулан сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс улсын бүртгэлийн байгууллагын www.burtgel.gov.mn /<http://election.burtgel.gov.mn/> цахим хуудаст байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоо 2.236.000.

ХОЁР. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн үүрэг чиглэлийн хүрээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг хуульчлах саналыг үндэслэн Засгийн газрын 2018 оны 394 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох журам болон 2018 оны 397 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмаас холбогдох зүйл заалтыг хуульд тусгаж, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, хянуулж эцсийн байдлаар боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд Улсын бүртгэлийн багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ХЗДХЯ-наас танилцуулсан.

Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар Монголын нотариатчдын танхимын гишүүн нотариатч нар дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл солилцон ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 270 нотариатчтай Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг байгуулсан байна. Мөн Монголын нотариатчдын танхимын төлөөлөлтэй 2024 оны 02 дугаар сарын 05 болон 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрүүдэд уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг Улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийн төлбөрийн төлөлтийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд иргэн бүрэн үйлчилгээгээ авах боломжтой талаар ярилцсан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас систем хөгжүүлэлтийн ажил бүрэн хийгдэж дууссан байгаа бөгөөд төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үйлчилгээний хураамж төлдөг дансны мэдээллийн жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд төлбөрийн системийн хөгжүүлэлтийг Монголын Нотариатчидын танхимын зүгээс хийж дуусгахаар хүлээгдэж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд улсын хэмжээнд нийт 236145 бүртгэл хийгдсэнээс өмчлөх эрхийн анхны бүртгэл 59562, гэрээний эрхийн бүртгэл 162234 бусад бүртгэл 14349 бүртгэгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний 2024 оны эхний 5 сарын тоон мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүртгэлийн тоо энэ онд 17984 буюу 8.24%-аар өссөн үзүүлэлттэй байна.

ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах төсөл болон Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх зорилгоор сумдын эрх зүйч мэргэжилтэй улсын бүртгэгч нарт мэдээллийн санд хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх нээсэн.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх мэдээллийг өрх бүрт хүргэх зорилгоор 1400 орчим төрийн албан хаагчдыг орон нутагт томилолтоор ажиллах шийдвэр гарсны дагуу газрын дарга Ж.Аюуш, улсын бүртгэгч Д.Эрдэнэцэцэг нар хоршооны улсын бүртгэл хөтлөх асуудлаар хэлэлцүүлэг, семинарт тус тус оролцож мэдээлэл өгч байна. Мөн аймаг, сумын улсын бүртгэгч нарт хоршооны улсын бүртгэлийг түргэн шуурхай бүртгэхэд чиглэсэн цахим хурал, заавар чиглэлийг тухай бүр өгч байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй шашны байгууллагын мэдээлэл, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын байршил, тоо, шашны урсгалын судалгаа, Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй шашны байгууллагын мэдээлэл, Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хугацаа болон шашны урсгалын дэлгэрэнгүй судалгааг тус тус гаргаж ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах 6853, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө бүртгүүлэхээр ирсэн 10208, улсын бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн 2066, нэмэлт бүртгүүлсэн 13621 хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу материалаа хэрхэн бүрдүүлж ирүүлэх талаар зөвлөгөө өгч, шаардлагатай баримт бичиг, маягтаар хангаж ажиллалаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn цахим хуудсаар хэвийн төлөвтэй 236673, улсны бүртгэлээс хасагдсан 33381 хуулийн этгээдийн мэдээллийг нээлттэй байдлаар харуулж байна.

“E-Mongolia” болон “E-Business” төрийн үйлчилгээний цахим порталаар 11 төрлийн лавлагаа, 42 төрлийн үйлчилгээ болгон нэмэгдүүлж тогтмол үзүүлж байна. Тайлангийн хугацаанд 43184 хүсэлтийг хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэсэн байна.

ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

- Байгууллагын хүний нөөцтэй холбоотой 318 тушаалын төслийг боловсруулж, баталгаажуулан, нэгдсэн дугаар олгож холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн.
- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 75 этгээдийн ХАСУМ-ийг цахим хэлбэрээр гаргуулан авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй төрийн захиргааны албан хаагчийн томилгоо хийх ажлыг зохион байгуулсан. Шинээр ажилд гэрээт ажилтан, төрийн үйлчилгээний албан хаагчтай ажил гүйцэтгэх болон хөдөлмөрийн гэрээг байгуулсан
- Монгол Улсын Засгийн газраас 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн мэдээллийн санд бүрэн шинэчилсэн. Засгийн газрын 2024 оны “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралтад өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоол, мөн оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 10, 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Б/218 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний зарим албан тушаалыг тогтоолд нийцүүлэн ТҮМ гэсэн ангилал руу шилжүүлсэн болно.
- Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд хэрэглэх **207** тэмдгийг захиалж хүргүүлсэн.
- Захиргааны ерөнхий хуулийн дагуу 26 дугаар зүйлд заасны дагуу Захиргааны акт, захиргааны гэрээр батлан гаргахын өмнө эрх хууль, ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар гаргах боломж олгоно гэж заасны дагуу нийт **47** удаа “Сонсох ажиллагаа”-г зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан болно.

- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ээлжийн амралын мэдэгдэх хуудсыг **18** албан хаагчид олгосон.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны Б/1306 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт хамгаалалт нууцлалын аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийн тухай бүр холбогдох газарт хүргүүлэн ажилласан. Нийт -**113** Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хандах эрхийг нээх, хаах-**60**, Хуулийн этгээдийн мэдээллийн нэгдсэн санд хандах эрхийг нээх, хаах-**21**, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд хандах эрхийг нээх, хаах-**23**

4.1.Төрийн албаны салбар зөвлөлийн хүрээнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1 удирдах, 45 /давхардсан тоогоор буюу 1 орон тоог удаа дараа зарласан тоо орсон/ гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулахаар захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудасны шалгалтын системд оруулсан ба зарыг уг цахим хуудсаар нийтэд мэдээлсэн. Тус газрын удирдах албан тушаалд хамаарах Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сүлжээ техникийн хэлтсийн даргын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, тухайн албан тушаалын шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан нэр бүхий иргэнийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлсэн. Гүйцэтгэх албан тушаалд хамаарах сул 45 орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 30, мөн оны 02 дугаар сарын 02, 02 дугаар сарын 27, 28, 03 дугаар сарын 28, 04 дүгээр сарын 22, 05 дугаар сарын 13-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, тухайн албан тушаалын шалгалтад тэнцэж, хамгийн өндөр оноо авсан 29 иргэнийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлсэн.

Тухайн албан тушаалын тусгай шалгалтад оролцохоор хүсэлтээ гаргасан иргэн, албан хаагчийн баримт бичиг, холбогдох материалыг цахимаар хүлээн авч бүртгэн, тусгай шалгалтыг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу сорил болон ярилцлага хэлбэрээр авч, удирдах албан тушаалд хамаарах 1, гүйцэтгэх албан тушаалд хамаарах 29 сул орон тоог холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нөхсөн. Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх сэлгэн ажиллуулах тухай зарыг 8 удаа нийтэд мэдээлж, гүйцэтгэх албан тушаалд хамаарах 15 орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхсөн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд энэ жилд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 8 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 230 албан хаагч хамрагдсан байна.

2024 оны эхний хагас жилд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр нийт 63 удаагийн мэдээ мэдээлэл байгууллагын цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн байна. Үүнээс байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк пэйж хуудас/ твиттер, инстаграм/-д давхардсан тоогоор 45 удаагийн мэдээ мэдээлэл байршуулсан бөгөөд видео мэдээ 25 удаа /үүнээс тодруулга-2 удаа/, фото мэдээ 109 удаа, мөн бусад холбоотой мэдээлэл буюу телевиз, сайт, сонинд өгсөн ярилцлага, мэдээ зэргийг пэйж хуудастаа 85 удаа байршуулжээ. Харин гэрээтэй болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 46 /гаруй/ удаагийн мэдээлэл хүргэсэн байна. Үүнээс телевизэд 24 удаагийн, сайтад 20 гаруй /давхардсан тоогоор/ удаа, сонинд 2 удаа мэдээ мэдээлэл нийтлэгдсэн байна. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байгаа мэдээ мэдээллийг тухай бүр шинэчилж /2-4 удаа/, байгууллагын тоон мэдээ болон санхүүгийн ил тод байдал цэсийг сар бүр, мэдээллийн самбарын мэдээ мэдээлэл хэсэгт цахим хуудаст байршуулсан мэдээ мэдээллээр тухай бүр сольж байна.

Төрийн албанд 44 болон 35 жил тасралтгүй ажиллаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор төрийн албанаас чөлөөлөгдсөн нэр бүхий 2 албан хаагчийг /2024.03.01/ байгууллагын хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж хүндэтгэл үзүүлэв.

Хуулиар зөвшөөрснөөс бусад ажил давхар эрхэлж байсан төрийн захиргааны 8 албан хаагчийг тухайн албан тушаалаас чөлөөлж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцов.

ТАВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

Тайлангийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яам, төрийн бусад байгууллагаас ирүүлсэн 4 хууль, 1 Засгийн газрын тогтоол, 2 журмын төсөлд санал хүргүүлж, Улсын бүртгэлийн 4 хууль, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 7 журам, 1 дүрмийн төслийг холбогдох нэгжтэй хамтран болон дангаар боловсруулж, батлуулсан.

5.1.Хууль тогтоомжийн төсөлд санал хүргүүлэх, төсөл боловсруулах:

5.1.1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 1/366 дугаар албан бичгээр ирүүлсэн “Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбогдох саналыг тусган 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар;

5.1.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох саналыг тусган 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/3703 дугаартай албан бичгээр;

5.1.3.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 05 сарын 13-ны өдрийн 1/243В дугаартай албан бичгээр ирүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох саналыг тусган 05 дугаар сарын 20-ны өдрийн 1/6807 дугаартай албан бичгээр;

5.1.4.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 03 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт цахимаар;

5.1.5.“Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын төсөлд холбогдох саналыг тусган Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр дотоод албан бичгээр;

5.1.6.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 7/803 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын төсөлд холбогдох саналыг тусган 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/2788 дугаартай албан бичгээр;

5.1.7.Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан “Журам, маягт, загвар батлах тухай” 2024 оны А/11, А/22 дугаартай тушаалаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам”-ыг шинэчлэн найруулж; “Журам, батлах тухай” 2024 оны А/12, А/23 дугаартай тушаалаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”; Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Журам батлах тухай” 2024 оны А/25 дугаартай тушаалаар “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам”-ыг тус тус шинээр боловсруулж батлуулсан. Мөн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/2005

дугаар албан бичгээр хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6699, 6700, 6701 дугаарт бүртгэсэн.

5.1.8.Эрх зүйн хэм хэмжээний үйлчлэл нь дууссан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Журам, маягт, загвар батлах тухай” 2020 оны А/372, “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хэсгийн дугаарыг тогтоох тухай” 2020 оны А/416 дугаартай тушаалыг тус тус хүчингүй болгож, захиргааны хэм хэмжээний актын бүртгэлээс хасуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/2238 дугаартай албан бичгээр;

5.1.9.Засгийн газрын 2018 оны 396 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрэм”, Засгийн газрын 2021 оны 125 дугаар тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам”, “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хаалттай мэдээлэлтэй танилцах, мэдээлэл өгөх журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/333 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/02 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/291 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тэмдэг хэрэглэх журам”-ын холбогдох заалтыг Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган, дээр дурдсан журмуудыг хүчингүй болгох саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт 03 дугаар сарын 01-ний өдөр цахимаар тус тус хүргүүлсэн.

5.2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдах эрх зүйн актын төсөл боловсруулах, хянах:

5.2.1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны “Загвар, журам шинэчлэн батлах тухай” А/1125 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан барьцаалбарын загвар, маягтууд, “Барьцааны зүйлийг худалдах тухай мэдэгдэл хүргүүлэх журам”-ын төсөлд холбогдох саналыг тусган Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт 04 дүгээр сарын 04-ний өдөр 284 дугаартай дотоод албан бичгийг цахимаар;

5.2.2.“Баримт нягтлан шалгах комиссын дүрэм”, “Байгууллагын архивын журам”-ын төсөлд холбогдох саналыг тусган Тамгын газарт 04 дүгээр сарын 24-ний өдөр 334 дугаартай дотоод албан бичгээр;

5.2.3.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Журам батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/25 дугаартай тушаалаар батлагдсан “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам”-д Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2024 оны А/64 дугаартай тушаалын төсөл боловсруулж батлуулсан.

Дээр дурдсан захиргааны хэм хэмжээний актын өөрчлөлтөд Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн шинжилгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэхээр холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1/5715 дугаартай албан бичгээр, zhha@mojha.gov.mn цахим хаягаар тус тус хүргүүлсэн.

5.2.4.“Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын төсөл, тушаалын төсөл, харьцуулсан судалгаа, танилцуулгыг бэлтгэн Даргын зөвлөлийн хурлаар 04 дүгээр сарын 23-ны өдөр хэлэлцүүлсэн.

5.2.5.“Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”-ын төсөл, харьцуулсан судалгаа, танилцуулга, тушаалын төслийг боловсруулж, 04 дүгээр сарын 25-

ны өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/63 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан.

5.3.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, гэрээний төслийг боловсруулах, хууль зүйн үндэслэлийг хянах, чиг үүргийн хүрээнд:

5.3.1.Хүний нөөцийн чиглэлээр “Ажилд томилох тухай”, “Ажлаас чөлөөлөх тухай”, “Албан хаагчид чөлөө олгох тухай”, “Албан хаагчид тусламж, дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох тухай”, “Сахилгын арга хэмжээ авах тухай” зэрэг Б тушаалын төсөл 227, ээлжийн амралт олгох тухай 2 мэдэгдэл;

5.3.2.Бусад газар, хэлтсээс боловсруулж ирүүлсэн “Ажлын хэсэг, Үнэлгээний хороо, байгуулах тухай”, “Зардал гаргах тухай”, “Томилолтоор ажиллуулах тухай” зэрэг А тушаалын 17 төсөл хянасан.Тухайлбал:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Журам, маягт, загвар батлах тухай” 2020 оны А/372, “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хэсгийн дугаарыг тогтоох тухай” 2020 оны А/416 дугаартай тушаалын эрх зүйн хэм хэмжээний үйлчлэл дууссан тул УБЕГ-ын даргын “Тушаал хүчингүй болсонд тооцох тухай” 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/21 дугаартай тушаалын төсөл;
- МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн санал авах өдөр нэгдсэн сангаас сонгогчийг таньж бүртгэх программ хангамж, гадаад улсад санал өгөх сонгуулийн эрх бүхий иргэнийг таньж бүртгэх программ хангамжийг хөгжүүлэх, бодлогын даалгавар боловсруулах үүрэг бүхий хамтарсан “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/10 дугаартай тушаалын төсөл боловсруулж батлуулсан.

5.3.3.Тайлангийн хугацаанд төрийн болон бусад байгууллагатай байгуулах 49 гэрээг гэрээний нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар олгон цахимжуулсан бөгөөд бусад нэгжүүдээс ирүүлсэн дараах гэрээний төслийг хянаж, холбогдох саналыг тусган эрх зүйн үндэслэлийг хангаж ажилласан. Үүнд:

5.3.3.1.“Ажил гүйцэтгэх гэрээ”, “Хөдөлмөрийн гэрээ”-ний төслийг хүний нөөцийн мэргэжилтэн Ж.Пүрэвнямд 01 дүгээр сарын 14-ний өдөр цаасаар;

5.3.3.2.“Гэрчилгээ маягт хэвлэн нийлүүлэх гэрээ”-ний төслийг Санхүү, аж ахуйн хэлтэст 01 дүгээр сарын 31-ний өдөр цаасаар;

5.3.3.3“Сонгогчдын бүртгэлтэй холбоотой программ хангамж нийлүүлэх”, “Принтерийн хор, битүүмжлэх лац нийлүүлэх”, “Бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах” гэрээний төслийг МТГ-ын ахлах мэргэжилтэн Бумчинд 02 дугаар сарын 22-ны өдөр цаасаар;

5.3.3.4.“Хүрд пресс” ХХК-тай байгуулах “Хэвлэлийн ажил гүйцэтгэх гэрээ”, “Хашхан” ХХК-тай байгуулах “Сонгуулийн тоног төхөөрөмжийг байрлуулах төмөр тавиур нийлүүлэх, угсрах” гэрээний төслийг Санхүү, аж ахуйн хэлтэст 02 дугаар сарын 22-ны өдөр цахимаар;

5.3.3.5.”Тридум Э-Секьюрити“ ХХК-тай байгуулах “Лиценз ашиглах эрх сунгах гэрээ”-ний төслийг Мэдээллийн технологийн газарт 02 дугаар сарын 15-ны өдөр цахимаар;

5.3.3.6.“Инвескор ББСБ” ХХК-тай байгуулах Хамтран ажиллах гэрээний төслийг МТГ-ын Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн дарга Б.Анхбаярт 03 дугаар сарын 22-ны өдөр цахимаар;

5.3.3.7.“Грийтпийк” ХХК-тай байгуулах “Бичгийн цаас нийлүүлэх гэрээ”-ний төслийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Бөртэ-д 03 дугаар сарын 14-ний өдөр цаасаар;

5.3.3.8.Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай байгуулах “Мэдэгдэл хүргэх систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний төслийг Мэдээллийн технологийн газарт 03 дугаар сарын 27-ны өдөр цахимаар;

5.3.3.9.“Иргэний үнэмлэхний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээний төслийг МТГ-ын ахлах мэргэжилтэн Б.Бумчинд 04 дүгээр сарын 03-ны өдөр цаасаар;

5.3.3.10.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн ажилтантай байгуулах “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний төслийг 05 дугаар сарын 27-ны өдөр нэгжүүдэд цахимаар тус тус хүргүүлсэн.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас бусад хуулийн этгээдтэй байгуулах 9 гэрээний төслийг боловсруулж, холбогдох эрх бүхий албан тушаалтан, хуулийн этгээдээс санал авч баталгаажуулан, гэрээний нэгдсэн бүртгэлд бүртгэж, холбогдох нэгжид хүргүүлэн ажилласан. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Смарткарт” ХХК-тай байгуулах 03 дугаар сарын 03-ны өдрийн “Монгол Улсын иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэх гэрээ”-ний төсөл;
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-тай байгуулах 02 дугаар сарын 20-ны өдрийн “Үндэсний энгийн гадаад паспорт /цахим/-ын бэлдэц нийлүүлэх гэрээний төсөл;
- “Ситисейф” ХХК-тай байгуулах 03 дугаар сарын 05-ны өдрийн “Архивын нягтруулсан шүүгээ угсрах гэрээ”-ний төсөл;
- “Өгөөмөр-Уул” ХХК-тай байгуулах 04 дугаар сарын 05-ны өдрийн Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засвар, дотоод заслын ажлыг гүйцэтгэх ажил гүйцэтгэх гэрээний төсөл;
- “Олон улсын стандартын академи” ХХК-тай байгуулах 05 дугаар сарын 27-ны өдрийн Захиалгат сургалтын гэрээний төсөл;
- “Метадата” ХХК-тай байгуулах 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Хамтран ажиллах гэрээ”-ний төсөл;
- “Смарткарт ХХК”-тай байгуулах 05 дугаар сарын 10-ны өдрийн “Төхөөрөмж /модем/ нийлүүлэх гэрээ”-ний төсөл;
- “Юнител ХХК”-тай байгуулах 05 дугаар сарын 17-ны өдрийн “Худалдан авах гэрээ”-ний төсөл;
- “Төрийн банк” ХК-тай байгуулах “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг хянаж 05 дугаар сарын 22-ны өдөр санал авахаар “Төрийн банк” ХК-д цахимаар хүргүүлсэн.

5.4.Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох ажлын хүрээнд:

Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэгдэж буй 2 хэрэг маргаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хэлтсийн ахлах мэргэжилтэн УБЕГ-ын даргын 2023 оны 1/9735, 2024 оны 1/734 тоот албан бичгээр томилогдон ажиллаж байна. Үүнд:

5.4.1.Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан иргэн Д.Өлзийсайхан, Л.Нямсүрэн нарын нэхэмжлэлтэй хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Л.Гансүхийн хамт томилогдож, хэргийн материалтай танилцаж хариу тайлбарыг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд шүүх хурал 2 удаа хуралдсан бөгөөд 05 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэрэгт холбогдох нотлох баримтыг гаргуулах хүсэлтийг УБЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар гаргаснаар шүүх хурлыг хойшлуулж 06 дугаар сарын 14-ний өдөр хуралдахаар товлогдсон.

5.4.2.Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан иргэн Б.Гүнсэнгийн нэхэмжлэлтэй хэрэг маргааны нэхэмжлэлийг 01 дүгээр сарын 23-ны өдөр гардан авч, шүүхэд 02 дугаар сарын 05-ны өдөр холбогдох нотлох баримтуудыг мэдээллийн сангаас хэвлэн авч, нотлох баримтын хуулбарыг нотариатаар батлуулан шүүгчийн туслахад биечлэн хүргэсэн. Өнөөдрийн байдлаар анхан шатны шүүх хурал хуралдаагүй байна.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

6.1.Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах хүрээнд:

ОХУ-ын Улсын Бүртгэл, Кадастр, Зураг зүйн газар /Росреестр/-тай 2017 онд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулагдсан. Үүний хүрээнд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэл дэх цахим шилжилтийн талаар санал солилцох тухай хамтарсан уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулсан. Тус газраас 2024 онд хоёр байгууллагын харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсний дагуу ХЗДХЯ-нд чиглэл хүсэх тухай албан бичгийг хүргүүлсний хариуд хүргүүлсний хариуд хамтын ажиллагааг эхлүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн хариу ирүүлсний хүрээнд 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 1\5394 тоот албан бичгээр ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хамтын ажиллагааг эхлүүлэх саналыг уламжлан өгөхийг хүсэх тухай албан бичгийг хүргүүлж тус ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Станислав Сергеевич Безруковтай шууд холбоо тогтоосон байна.

6.2.Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх:

Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцааны санхүүжилтээр бүртгэлийн байгууллагад 2023-2025 онд хэрэгжих “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан төслийн захирал, удирдах хороог баталсан тушаалыг гаргуулсан ба баримт бичгийн бүрдлийг ханган ажиллаж байна. 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр төслийн нээлтийн семинарыг ТХН-тэй хамтран амжилттай зохион байгуулсан. Төслийн хүрээнд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн гадаад болон дотоодын чадавхжуулах сургалтуудыг үе шаттайгаар эхлүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Ухаалаг Засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Дэлхийн банк болон УБЕГ хамтарсан уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газраас төслийг соёрхон баталж албан ёсоор 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлүүлсэн. Тус төсөлд УБЕГ-аас хүргүүлсэн 3 төрлийн саналаас тоног төхөөрөмж техник хангамжтай холбоотой санал дэмжигдсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсантай холбоотой төслийн баримт бичиг шинэчлэн хүргүүлэх тухай уулзалтыг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ЦХХХЯамнаа Дэлхийн банкны төлөөллүүдтэй хамтран хийсэн. Төслийн саналыг шинэчлэн 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр төслийн нэгжид хүргүүлсэн байна. Дэлхийн банкнаас баримт бичигт өөрчлөлт оруулах санал ирүүлсний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр саналыг тусгасан баримт бичгийн англи хувилбарыг Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлэн ажиллав.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын санхүүжилтээр тус улсын шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвөөс 2023-2025 онд хэрэгжүүлэх “Улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд эхний шатны сургалтыг 2023.09.10-2023.09.22-ны өдрүүдэд БНСУ-д зохион

байгуулж, тус сургалтад удирдах түвшний **25** албан хаагч хамрагдсан. 2024 оны ээлжит сургалтыг 09 дүгээр сард зохион байгуулах бөгөөд нийт 15 албан хаагч хамруулах тухай албан бичгийг тус байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн байна.

6.3.Албан хаагчдын гадаадад томилолтоор ажиллах, сургалтад хамрагдах асуудлаар гадны болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд:

- 2023.11.28-2023.12.01-ны өдрүүдэд БНХАУ-ын Шинжинь хотноо зохион байгуулагдах Олон улсын архивын консулын Зүүн азийн салбар /EASTICA/-ын 2023 оны ээлжит хуралдаанд УБНА-ын **2** албан хаагч оролцсон.
- Мөн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА, КэйДиЭс /KDS/-уудтай хамтран Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хэрэгжиж буй “Монгол улсын төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд **1** албан хаагч БНСУ-ын Хүний нөөцийн хөгжлийн үндэсний институт /NHI/-д 2024 оны 04 дүгээр сарын 22-ноос 27-ны өдрүүдэд хамрагдсан.
- 2024 оны Улсын их хурлын ээлжит сонгуулийн ажлын хүрээнд гадаад улс дахь элчин сайдын яамдуудад ИУБГ, МТГ, ХШГ болон холбогдох газар хэлтсүүдийн албан хаагчид томилолтоор ажиллах тухай ерөнхий газрын даргын тушаал гарсан. Уг ажлын хүрээнд Монгол Улсаас Хилийн Чанадад суугаа 14 улсын Дипломат төлөөлөгчийн газарт ВПН ашиглан Улсын бүртгэлийн онлайн системийг холбохоор 20 албан хаагч томилолтоор ажилласан.
- АХБ-ны төслийн хүрээнд БНСУ-ын Шүүхийн харьяа төрийн албан хаагчдын сургалтын төвтэй хамтран 14 албан хаагчийг чадавхжуулах сургалтад 2024 оны 4 дүгээр сарын 20-ноос 27-ны өдрүүдэд хамруулсан.

Улсын бүртгэлийн байгууллага нь 2024 оныг хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих жил болгон зарласны хүрээнд ХЗДХЯ-ны харьяа агентлагууд, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай байнгын хамтын ажиллагааг эхлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Тус зорилтын хүрээнд уулзалт зохион байгуулах, харилцан туршлага солилцох, хамтарсан сургалт арга хэмжээ зохион байгуулахаар Гадаадын иргэн, харьяатын газар болон гадаад улсаас Монгол Улсад Суугаа Элчин сайдын яаманд хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны холбогдох албаны төлөөлөгч нартай 2024.06.10-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Мөн олон улс болон орон нутгийн нислэгийн тийз захиалга, үйлчилгээ үзүүлдэг Эйр Экспресс трэйвэл ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. АХБ-ны төслийн хүрээнд БНСУ-ын Шүүхийн харьяа төрийн албан хаагчдын сургалтын төвтэй хамтран 13 албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

6.4.Гадны байгууллага, төлөөлөгчтэй хийх аливаа уулзалт, арга хэмжээг зохион байгуулах:

- АНУ-д төвтэй Смартматик ХХК-ийн төлөөллүүдтэй 2024 оны 1 дүгээр улиралд УБЕГ-ын Сонгуулийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2 удаагийн хамтарсан уулзалтыг зохион байгуулж ажилласан.
- Ухаалаг Засаг 2 төслийн талаар Дэлхийн банкны төлөөлөл болон ТХН-тэй хамтарсан техник уулзалтыг 2024 оны 02 дугаар сарын 21, 23-ны өдрүүдэд зохион байгуулж УБ-ийн байгууллагын удирдлагууд, МТГ-ын ажилчид уулзалтад оролцлоо.

6.5.Гадаад харилцаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох газруудад тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллах ажлын хүрээнд:

ХЗДХЯ-наас 2023 оны гадаад харилцааны төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны гадаад харилцааны чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг бэлтгэн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн бөгөөд ХЗДХЯ-наас ирүүлсэн

6 албан бичгийг шийдвэрлэж, ногоон паспорт эмэмшигч албан хаагчдийн судалгаа зэргийг гарган хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Мөн 2023 оны 23 мэдээний англи

хувилбарыг www.burtgel.gov.mn сайтад хөтлөн байршуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр ХЗДХСайдын айлчлалтай холбоотой мэдээ англи хувилбараар мөн байршсан байна. Түүнчлэн Бусад байгууллагаас ирүүлсэн 6 удаагийн гадаад албан бичиг болон танилцуулга материал зэрэг баримтуудыг орчуулан танилцуулж ажиллалаа. Мөн холбогдох төслийн баримт бичиг болон албан бичиг зэрэг 21 орчим хуудас материал орчуулсан байна.

6.6.Гадаадад томилолтоор явах албан хаагчдад визны материал бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах, холбогдох газарт хүсэлтүүдийг нь илгээх ажлын хүрээнд:

2024 оны Улсын их хурлын ээлжит сонгуулийн ажлын хүрээнд гадаад улс дахь элчин сайдын яамдуудад ИУБГ, МТГ, ХШГ болон холбогдох газар хэлтсүүдийн албан хаагчид томилолтоор ажиллах тухай ерөнхий газрын даргын тушаал гарсан. Уг ажлын хүрээнд 15 улсад давхардсан тоогоор 30 орчим албан хаагч ажиллахаар товлогдсон бөгөөд тухай бүрт гадаад хэл дээрх тодорхойлолтыг гарган анкет бүрдүүлэлтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн тухайн албан хаагчдад хилийн шалган нэвтрүүлэх албанд шаардлагатай тохиолдолд өгөх дэмжлэг хүсэх тухай гадаад албан бичиг 15 удаагийн албан бичиг төлөвлөн гаргасан.

ДОЛОО.ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн байгууллага 2024 онд нийт 6 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийсэн бөгөөд Үүнд: “Ikon.mn, Vip76, Ugluu.mn, amlalt.mn, sanuulga.mn, Eagle tv” гэсэн 5 сайт 1 болон телевизийн байгууллага орно. 2024 оны эхний жилд гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр Улсын бүртгэлийн байгууллагатай холбоотой нийт 66 мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. УБЕГ-ын 2024 онд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагын хүрээнд “Etv, Eagle, Tv8, Tv9, Ntv, Ikon” гэсэн 5 телевиз, “Vip76, Ugluu.mn, Unuudur.mn, Amlalt.mn, Sanuulga.mn, Нэгүүн,мн, Zugii.mn, NM news.mn, Khotoch.mn, Zarig.mn, Төр.мн, HumanZ, MNB, Dorgio.mn, 25tv, Zugii.mn” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад ярилцлага, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.

2024 оны эхний хагас жилд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр нийт **145** удаагийн мэдээ мэдээлэл, орсон бол сайтад нийт **112** удаагийн мэдээ орсон байна.

Үүнээс видео мэдээ **32**, постер мэдээ **65**, текстэн болон зурган мэдээ **49** удаа орсон байна. Мөн бусад хэвлэл мэдээллийн байгууллагад нийт **32** удаагийн ярилцлага болон мэдээлэл өгсөн ба “Etv, Eagle, Tv8, Tv9, Ntv, Ikon, Vip76, Ugluu.mn, Unuudur.mn, Amlalt.mn, Sanuulga.mn, Zugii.mn, NM news.mn, Khotoch.mn, Zarig.mn, Төр.мн, HumanZ, MNB, Dorgio.mn, 25tv, Zugii.mn” гэх сайт болон телевизтэй хамтран ажиллаж, мэдээ мэдээллээр ханган олон нийтэд түгээж ажилласан. Мөн Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг 2024 оны хагас жилд Улсын бүртгэлийн ерөнхий газрын вэб сайт болон цахим хуудаст 12 удаа байршуулан нийтэлсэн байна.

Улсын бүртгэлийн байгууллагийн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг ил болгох ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд нийт **54** удаагийн мэдээ мэдээлэл байршуулсан ба Хуульд заасан холбогдох мэдээллүүдийг ил болгох ажлын хүрээнд байгууллагын пэйж хуудас дээр **58** удаагийн мэдээ мэдээлэл байршуулсан байна.

НАЙМ.СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан газар, хэлтсүүдээс 2024 онд зохион байгуулах сургалтын саналыг нэгтгэн даргын зөвлөлийн хурлаар 3 удаа танилцуулагдсан бөгөөд 2024 оны 05 сарын 2-ний өдөр сургалтын төлөвлөгөө эцэслэн батлагдсан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан

хаагчдын мэдлэг чадавхыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд энэ жилд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд **45** удаагийн сургалт зохион байгуулж **7817** албан хаагч хамрагдсан байна. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын **23** удаагийн дотоод сургалтаар **7769** албан хаагч хамрагдсан бол Засгийн газрын болон бусад төрийн байгууллагын зохион байгуулж буй **22** удаагийн сургалтад **48** албан хаагч хамрагдсан.

5.1. Хүний нөөц, сургалтын цахим систем ашиглалтыг нэмэгдүүлэх сургалт:

1. Хүний нөөц сургалтын системийн хичээлийг 2023 онд 144, 2024 онд 9 нийт 153 албан хаагч үзэж судалсан байна.
2. Иргэний улсын бүртгэлийн газраас 15 тушаал, чиглэл, журам, гарын авлага зэргийг байршуулсан байна. Давхардсан тоогоор 45 албан хаагч үзэж судалсан байна.
3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2 чиглэл байршуулснаас 5 албан хаагч мэдээллийг үзэж судалсан байна.
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 19 тушаал, чиглэл, журам, гарын авлага зэргийг байршуулсан байна. Давхардсан тоогоор 19 албан хаагч үзэж судалсан байна.
5. Хяналт шалгалтын газраас 10 тушаал, чиглэл, журам, гарын авлага зэргийг байршуулсан байна. Давхардсан тоогоор 18 албан хаагч үзэж судалсан байна.
6. УБНА-ын 5 гарын авлага зэргийг байршуулсан байна. Давхардсан тоогоор 8 албан хаагч үзэж судалсан байна.
7. Төрийн албан хаагчийн харилцаа хандлага ёс зүйн сургалтыг 4 албан хаагч үзэж судалсан байна.
8. Эрх зүйн хэлтсээс эрхлэн гаргадаг Сониныг дугаар №2 12, дугаар №3 12, дугаар №4 11, дугаар №5 5, дугаар №6 3 нийт давхардсан тоогоор 43 албан хаагч үзэж судалсан байна.
9. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг байршуулан ажилласан. 1 албан хаагч үзэж судалсан байна.

№	Хичээлүүд	Үзэж судалсан албан хаагчийн тоо
40 Видео хичээл		
1	Цагаан толгой 10 хичээл	1
2	Дүрмийн 6 хичээл	1
3	Нэр үгийн 5 хичээл	1
4	Үйл үгийн 8 хичээл	1
5	Үгсийн аймгийн 7 хичээл	1
6	Дагавар 4 хичээл	1
Нийт видео хичээл үзсэн тоо		6
Цахим ном		
1	Үндэсний бичиг 6-р анги	1
2	Үндэсний бичиг 7-р анги	
3	Үндэсний бичиг 8-р анги	1
4	Үндэсний бичиг 9-р анги	
5	Үндэсний бичиг 10-р анги	
Нийт цахим ном үзсэн тоо		2
Видео, цахим ном үзсэн тоо		2024 онд- 575 албан хаагч

д/д	Хичээлийн сэдэв	1-р үе шат	2-р үе шат	3-р үе шат	Шалгалт	Нийт
1.	Ерөнхий мэдлэгийн хичээлийг				787	777
2.	Иргэний улсын бүртгэлийн хичээл	751	724	701	642	2818
3.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хичээл	596	491	460	429	1976

4.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хичээл	584	543	520	489	2136
5.	Улсын бүртгэлийн нэгдсэн архивын хичээл	496	479	475	443	1893
Нийт 17 удаагийн сургалтаар		2427	2237	2156	2790	9600

2024 оны I ба II улирлыг харьцуулсан үзүүлэлт:

д/д	Хичээлийн сэдэв	2024 I улирал	2024 II улирал	Нэмэгдсэн
1.	Ерөнхий мэдлэгийн хичээлийг	777	787	10
2.	Иргэний улсын бүртгэлийн хичээл	632	642	10
3.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хичээл	415	429	14
4.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хичээл	423	489	66
5.	Улсын бүртгэлийн нэгдсэн архивын хичээл	415	443	28
Нийт тоо:		2662	2790	128

2024 оны эхний хагас жилийн байдлаар 128 албан хаагч бие даах хичээлийг үзэж судалсан байна.

5.2.Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн:

1 дүгээр сарын сургалт:

- 2024.01.04-ний өдөр худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай сургалтад 5 албан хаагч хамрагдсан.
- 2024.01.25-ны өдөр Кибер аюулгүй байдлын чадамжийн төлөвшлийн загвар болон стандарт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
- 2024.01.25-ны өдөр МУИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар чиглэл өгөх сургалтыг зохион байгуулж сургалтад танхимаар 6 цахимаар 100 нийт 106 албан хаагч хамрагдсан.
- 2024.01.26-ны өдөр Нью Даймонд академитай хамтран Сөрөг хандлага сэтгэлгээ сэдэвт сургалтад танхимаар 46 цахимаар 78 нийт 124 албан хаагч хамрагдсан.
- Удирдлагын академийн сургалтад төсвийн зардлаар ахлах түшмэлд 1, мэргэшүүлэх дунд хугацааны мэргэшүүлэх багш сургалт 3, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-1 нийт 5 албан хаагч хамрагдсан. Хувийн зардлаар ахлах түшмэлийн багц сургалтад 2 албан хаагч хамрагдсан. Нийт сургалтын тоо: 5 удаагийн сургалтаар 243 албан хаагч хамрагдсан.

2 дугаар сарын сургалт:

- 2024.02.06-ны өдөр МУИХ-ын сонгуулийн тухай хууль түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалтыг 21 аймаг 9 дүүрэгт зохион байгуулсан. Нийт 741 албан хаагч хамрагдсан.
- 2024.02.28-ны өдөр Кибер аюулгүй байдлын зөвлөл, Цахим харилцаа хөгжил, харилцааны яам, Япон улсын GMO интернэт групптэй хамтран кибер аюулгүй байдлын чиглэлээр 2 албан хаагч хамрагдсан.
- 2024.02.23-ны өдөр Удирдлагын академийн “Төсвийн үр ашигтай зохицуулалт” сэдэвт сургалтад 2 албан хаагч хамрагдсан.
- 2024.02 дугаар сард Удирдлагын академийн чиглүүлэх богино зайн сургалтад НУБГ-ын 5 албан хаагч хамрагдсан.

5. 2024.02 дугаар сард Удирдлагын академийн Удирдах арга барил сэдэвт сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Нийт сургалтын тоо: 5 удаагийн сургалтаар 753 албан хаагч хамрагдсан.

3 дугаар сарын сургалт:

1. 2024.03.04 Монгол улсын харилцаа холбооны зохицуулах хороо болон Ази номхон далайн бүсийн сүлжээ мэдээллийн төв байгууллагатай хамтран зохион байгуулж буй “Сүлжээ ба интернэтийн замчлахын үндэс” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
2. Архивын ерөнхий газрын мэргэшүүлэх сургалтад УБЕГ-ын 4 бичиг хэргийн эрхлэгч хамрагдсан.
3. 2024.03.11 өдөр Удирдлагын академийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал сэдэв сургалтад 2 албан хаагч хамрагдахаар албан бичиг хүргүүлэн ажилласан.
4. 2024.03.12-ны өдөр СЕХ-оос зохион байгуулсан Сонгуулийн боловсрол сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
5. 2024.03.14-ны өдөр Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал зуршил сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 37 цахимаар 147 нийт 184 албан хаагч хамрагдсан.
6. 2024.03.18-ны өдөр Увс аймгийн УБХ-ийн албан хаагчдад УБНА-ын газраас сургалт зохион байгуулж 17 албан хаагч хамрагдсан.
7. 2024.03.22-ны өдөр ХЭУБГ-тай хамтран хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд тулгамдсан асуудлаар мэдээлэл өгөх, баталгаажуулах ” сэдэвт танхимын кейс ажиллагаатай сургалтыг зохион байгуулж,13 албан хаагчид хамрагдсан. Тус сургалтад ХШГ-аас хяналтын улсын байцаагч оролцож зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан.
8. 2024.03.22-ны өдөр зохион байгуулсан “МУИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт”, “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам”-ын танилцуулга, мэдээлэл, “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам”-ыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал сэдэвт сургалтууд танхимаар 20 цахимаар 313 нийт 333 албан хаагч хамрагдсан.
9. 2024.03.29-ны өдөр “Гадаад улсад байгаа иргэдийн СНХЖ үйлдэх, хүргүүлэх журам”-ын танилцуулга, мэдээллийг ЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн З.Ганцэцэг, “СНЖ үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”-ын танилцуулга мэдээллийг ЭЗХ-ийн мэргэжилтэн С.Амбасэлмаа,“Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам” “СНЖ үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”-ыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал сэдвээр ИУБГ-ын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг мэдээлэл хүргэн ажилласан.Нийт танхимаар 16 цахимаар 295 нийт 311 албан хаагч хамрагдсан.
10. Удирдлагын академийн сургалтад хувийн зардлаар эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1, ахлах түшмэлийн багц сургалтад 4 нийт 5 албан хаагч сургалтад хамрагдсан. Нийт сургалтын тоо: 10 удаагийн сургалтаар 871 албан хаагч хамрагдсан.

4 дүгээр сарын сургалт:

1. 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр аймаг, нийслэл дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Эх нотлох баримтыг цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаа”-нд анхаарах сэдвээр ахлах мэргэжилтэн Т.Байгалмаа, ахлах архивч Н.Ганцэцэг нар цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 337 албан хаагч хамрагдсан.
2. 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад “Эх нотлох баримтыг цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаа”-нд анхаарах сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 23 албан хаагч хамрагдсан.
3. 2024.04-05 ны өдрүүдэд удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдаж 50 албан хаагч хамрагдсан. 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр сургалтад оролцож буй албан хаагчид Удирдлагын академи дээр “Төрийн байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн

- төлөвлөлт, үнэлгээ”, “Төрийн байгууллагын шийдвэр гаргалтад ашиглах өгөгдлийн шинжилгээ” сэдэвт 4 цагийн сургалтад танхимаар хамрагдсан.
4. 2024.04.08-ны өдөр Монгол улсын цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас “WITS CSF PROFILE болон тэргүүлэх аргачлалыг ашиглах нь” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
 5. 2024.04.10-ны өдөр “Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтын Эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Сургалтад танхимаар 23 цахимаар 90 нийт 113 албан хаагч хамрагдсан.
 6. 2024.04.11-ний өдрийн цахим хөгжил, харилцаа холбооны яам Дэлхийн банкны хамтын ажиллагааны хүрээнд “Кибер аюулгүй байдлын эрсдлийн удирдлагын хүрээ” сэдэвт сургалтад МТГ-ын 1 албан хаагч хамрагдсан.
 7. 2024.04.10,12-ны өдрийн цахим хөгжил, харилцаа холбооны яам Дэлхийн банкны хамтын ажиллагааны хүрээнд “Кибер аюулгүй байдлын эрсдлийн удирдлагын хүрээ” сэдэвт сургалтад МТГ-ын 1 албан хаагч хамрагдсан.
 8. 2024.04.17-ны өдрөөс 19-ны өдрийг хугацаанд “УБЕГ-ын харьяа байгууллагуудын e-accounting системийн нэвтрүүлэлт сэдэвт” санхүүгийн албан хаагчдын нэгдсэн танхимын сургалтыг СААХ-тай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт 45 албан хаагч хамрагдсан.
 9. 2024.04.18-ны өдөр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг Эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Сургалтад цахимаар 150, танхимаар 29 нийт 179 албан хаагч хамрагдсан.
 10. 2024.04.18-ны өдөр Говьсүмбэр, Хөвсгөл аймаг, Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн албан хаагчдад “Эх нотлох баримтыг цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаа”-нд анхаарах сэдвээр ахлах архивч Н.Ганцэцэг болон мэргэжилтэн Г.Дуламсүрэн нар цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 145 албан хаагч хамрагдсан.
 11. 2024.04.24-ний өдөр Удирдлагын академиас зохион байгуулсан “Иргэн төвтэй хөгжилд засаг захиргааны анхан шатны нэгжийн удирдлагын оролцоо” сэдэвт олон улсын форумод НУБГ-ын 3 албан хаагч хамрагдсан.
 12. 2024.04.25,26-ны өдрүүдэд “Төрийн архивын удирдах ажилтан,улсын байцаагчдын нэгдсэн зөвлөгөөн” УБНА-ын газрын 2 ахлах мэргэжилтэн хамрагдсан.
 13. 2024.04.26-ны өдөр газар хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, дадлагажуулах сургалтыг зохион байгуулах,Нийслэлийн 6 дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд тудгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, хяналт тавих, мэргэжил арга зүй, удирдлагаар хангахад оршсон сургалтыг зохион байгуулагдлаа.Сургалтад Нийслэлийн 6 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нар танхимаар, 21 аймаг Багануур дүүргийн УБХ-ийн хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн дарга нар цахимаар хамрагдлаа. Сургалтад танхимаар 25 албан хаагч хамрагдахаас сургалтын ирц 88%-тай буюу 22 албан хаагч хамрагдсан бол цахимаар 23 хамрагдахаас 42 албан хаагч оролцсон. Нийт 64 албан хаагч сургалтад хамрагдсан байна.
 14. 2024.04 Удирдлагын академийн ахлах түшмэлийн багц сургалтад 1 аймгийн 1 албан хаагч, чиглүүлэх богино хугацааны сургалтад 5 аймгийн 5 албан хаагч нийт 6 албан хаагч 2 төрлийн сургалтад хамрагдсан.
 15. 2024.04 дүгээр сард Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд БНСУ-д туршлага судлуулах,чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад НУБГ-ын удирдах 14 албан хаагчид хамрагдсан. Нийт сургалтын тоо: 15 удаагийн сургалтаар 984 албан хаагч хамрагдсан.

5 дугаар сарын сургалт:

1. 2024.05.01-02-ны өдрүүдэд Хилийн чанадад ажиллаж байгаа 46 ДТГ-ын ажилтан нарт программын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Тамгын газрын дарга Г.Цолмон болон МТГ-ын программист С.Дэлгэрмөрөн нар мэдээлэл өгч оролцлоо.

2. 2024.05.29-ны өдөр Эрх зүйн хэлтэстэй хамтран "Баримт бичгийн эргэлтийн журмыг танилцуулах" сургалтыг зохион байгуулсан. Сургалтад танхимаар 29 цахимаар 149 нийт 178 албан хаагч хамрагдсан.
3. 2024.05.29-ны өдөр 21 аймгийн бичиг хэргийн эрхлэгч нарт "Баримт бичгийн эргэлтийг тооцох" сэдэвт сургалтыг Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч нартай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт 26 албан хаагч хамрагдсан.
4. 2024.05.30-ны өдөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан танхимын сургалтыг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нарт зориулсан зохион байгууллаа. Сургалтад нийт 15 албан хаагч хамрагдсан.
5. 2024.05.31-ний өдөр Удирдлагын академийн багш Т.Саранчимэгтэй хамтран Албан хэрэг хөтлөлтийг оновчтой зохион байгуулах, баримт бичиг зохион бүрдүүлэх нь сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Танхимаар 35, цахимаар 61 нийт 96 албан хаагч сургалтад хамрагдсан.
6. 2024.05.30-ны өдөр МУИХ-ын ээлжит сонгуулийн бэлтгэл ажлыг хангах, мэдээлэл өгөх үүднээс СНЖ хэвлэхтэй холбоотой анхаарах асуудлын хүрээнд цахим сургалт зохион байгуулсан. Нийт 46 улсын ахлах бүртгэгч нар хамрагдсан. Нийт сургалтын тоо: 6 удаагийн сургалтаар 407 албан хаагч хамрагдсан.

6 дугаар сарын сургалт:

1. 2024.06.03-05-ны өдрүүдэд Олон улсын стандартын академитай хамтран MNS/ISO 31000:2022" ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТ" -ын мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад танхимаар 30 цахимаар 21 нийт 51 албан хаагч хамрагдсан.
2. 2024.06.03-ны өдөр "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан. Сургалтад Хамтын ажиллагаа сургалтын хэлтэс болон НУБГ-ын Харилцагчийн үйлчилгээний албан хаагчид хамрагдсан. Нийт 8 албан хаагч хамрагдав.
3. 2024.06.13-ны өдөр Сонгогчийг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийн талаар Ажлын хэсэг, холбогдох албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулж нийт 100 албан хаагч хамрагдсан.
4. 2024.06.17-21 өдрүүдэд 2198 хэсгийн хорооны 2200 итгэмжлэгдсэн ажилтан нар эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.
5. 2024.06 дугаар сард 21 багийн 60 албан хаагч 21 аймаг, 9 дүүрэгт ажиллаж сургалтыг зохион байгуулсан. Нийт 2198 хэсгийн хорооны 2200 итгэмжлэгдсэн ажилтан нар сургалтад хамрагдсан.
6. 2024.06 дугаар сард Иргэний улсын бүртгэлийн офлайн системийг онлайн системд холбосонтой холбоотойгоор хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ын бүртгэлийн ажилтанд чиглэл өгөх нэгдсэн сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтын хүрээнд УБНА-ын газрын албан хаагчид "Эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгоход анхаарах асуудал" сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтад 46 албан хаагч хамрагдсан./үүнийг хийнэ/ Нийт сургалтын тоо: 5 удаагийн сургалтаар 4605 албан хаагч хамрагдсан.

ЕС.АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн байгууллага, иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэх, удирдлагад танилцуулах, байгууллагаас гадагш илгээж буй албан бичгийг бүртгэж дугаарлах болон шууданд илгээх, стандартын дагуу албажуулан албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулсан.

Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-д 2022 оны 212, 360 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/780 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын "Баримт бичгийн эргэлт зохион байгуулах журам"-ыг шинэчлэн

батлах хэрэгцээ шаардлагатай тул Байгууллагын хэмжээнд газар, хэлтсээс санал авч нэгтгэн Эрх зүйн хэлтэстэй хамтран боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/63 дугаар тушаалын хавсралтаар 11 бүлэгтэй “Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг батлуулсан.

2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр Байгууллагын нийт албан хаагчид журмын танилцуулах зорилгоор Эрх зүйн хэлтэстэй хамтарч сургалт зохион байгуулсан. Нийт ирсэн албан бичиг -10311 /53,362 хуудас/

- Хариутай албан бичгийн тоо - 2904
- Шууд шилжүүлсэн албан бичгийн тоо - 7407
- Байгууллагаар бүртгэсэн бичгийн тоо -3292
- Цахимаар ирсэн бичгийн тоо-7019

Иргэн, хуулийн этгээдээс ирсэн 11071 албан бичиг буюу нийт 56,531 хуудас цахим болон цаасаар ирсэн бичгийг “e-Doc” цахим системд бүртгэн холбогдох удирлагад шилжүүлж,

Үүнээс цаасан хэлбэрээр 4052 ирсэн бичгийн 27,000 хуудас баримтийг цахим мэдээллийн системд сканердаж цахимжуулан бүртгэж шилжүүлж, удирдлагын цохилтын дагуу газар, хэлтэст хүлээлгэн өгсөн.

Нийт явуулсан албан бичиг - 7354 /122,942 ху/

Үүнээс:

- Цахимаар боловсуулсан бичгийн тоо-3788 /55,855 хуудас/
- Цаасаар боловсруулсан бичгийн тоо - 3334 /66,417 хуудас/
- Дотоод албан бичиг -387/670 хуудас/

Байгууллагын газар, хэлтсээс цаасан суурьт төслөөр ирсэн А4-604, А5-213 нийт 817 албан бичиг, 129 тушаал болон тоон гарын үсгээр баталгаажсан /цахим хэлбэрээр боловсруулсан/ 3788 албан бичиг нийт 4734 баримт бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулган хэвлэсэн байна.

Иргэн, хуулийн этгээдэд нийт 132 өргөдөл гомдлын хариуг утсаар мэдэгдэж гарын үсэг зуруулж хүлээлгэн өгсөн бөгөөд 3196 ширхэг албан бичгийг дугтуйлж хаяглан шууданд илгээсэн.

Гадны байгууллага, иргэнд 7354 явуулсан албан бичиг явуулсанаас нийт цаасан суурьт боловсруулсан 3334 явуулсан албан бичиг 66,417 хуудас баримтийг мэдээллийн системд цахимжуулж оруулсан байна.

Тоон гарын үсэг ашиглан албан бичиг болон дотоод албан бичиг цахимаар солилцсоноор 11,194 баримт бичгийн шуудан, хүргэлтийн зардал, 77,582 хуудас цаас хэмнэж баримт бичгийн эргэлтийг сайжруулсан.

Байгууллагын баримт бичгийн эргэлтийн мэдээг хагас жилийн байдлаар нэгтгэн гаргахаар газар, хэлтсүүдэд дотоод албан бичгийг хүргүүлсэн байна. Байгууллагын газар, хэлтсээс цаасан суурьт төслөөр ирсэн 817 албан бичиг, 129 тушаал болон тоон гарын үсгээр баталгаажсан /цахим хэлбэрээр боловсруулсан/ 3788 албан бичиг нийт 4374 баримт бичгийг стандартад хяналт тавьж, хэвлэмэл хуудсанд буулган архивын хэрэг бүрдүүлэхээр цэгцэлсэн.

2017-2022 оны Байгууллагын өргөдөл, гомдол болон ирсэн, явуулсан албан бичгийг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр “Эйбл” албан хэрэг хөтлөлтийн системийг ашиглах хугацаанд системд ачаалж оруулсан 151 GB өгөгдлийн хэмжээтэй файлуудыг хатуу дискт хуулж, акт үйлдэн хүлээн авсан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгын хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим санах ойг үүсгэх, баримтын бүрдүүлэлт үүсгэх, баримтын бүртгэл, хадгалалт, ашиглалтын явцад цахим архивын системийг нэвтрүүлэх асуудлаар

Манай 2024 оны 04 дүгээр сарын 02-ны 1/4145 дугаар албан бичгээр чиглэл хүссэн дагуу Архивын ерөнхий газрын шинээр хөгжүүлэлт хийгдэж буй Архивын цахим системийг ашиглах болон дээрх /151 GB/ өгөгдлийг цахим архивын дата болгон ашиглах талаар мэдээлэл солилцож ажилласан.

АРАВ. САНХҮҮ, АЖ АХУЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн ажлын хүрээнд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүү, аж ахуйн хэлтэс нь санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх орлогоор 45,0 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөө 56,5 хувийн биелэлтэй байна.
- 2024 онд 44.651,0 сая төгрөгийн батлагдсан төсвөөс эхний 5 сарын байдлаар төсвийн 98,5 хувийг зарцуулаад байна.
- Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийн шууд захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, холбогдох тодруулгын хамт 2024 оны 01 сарын 25-ны өдөр, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн 23 нэгжээр нэгтгэсэн тайланг гарган, холбогдох тодруулгын хамт Үндэсний аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/2821 тоот албан бичгээр, Хууль зүй, дотоод хэргийн яаманд аудитаар баталгаажуулсан 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 1/3750 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.
- 2023 оны санхүүгийн 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг 22 нэгжээс нэгтгэж хуульд заасан хугацаанд тайлагнаж, удирдлагад танилцуулж ажилласан. Байгууллагын 23 нэгжээс сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст сар бүрийн 4-ний өдөр өглөг, авлагын мэдээ, тооцоо нийлсэн актын хуулбарын хамт хүргүүлж ажиллаж байна.
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 147 мэдээллийг үнэн зөв гаргаж тогтоосон хугацаанд шилэн дансны цахим хуудас болон төвлөрүүлэн захирагчийн цахим хуудсанд сарын 05-ны дотор байршуулах ёстой мэдээллүүдийг хугацаандаа бүрэн байршуулан ажилласан.
- Байгууллагын төсөв хариуцсан ажилтантай хамтран шаардлагатай санхүүгийн нөөцийг цаг хугацаанд нь бүрдүүлж хэвийн үйл ажиллагааг ханган үүднээс батлагдсан төсвийн хүрээнд Сангийн сайдын баталсан зардлын дагуу зарлагыг гаргаж, баримтын бүрдлийг ханган холбогдох зарлагыг гаргаж, хуульд заасан хугацаанд Сангийн яамны Е тайланд төсвийн гүйцэтгэлийн мэдээг шивж баталгаажуулж ажиллаж байна.
- 2024 оны төсвөөр урсгал санхүүжилт, ялангуяа ашиглалт, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардал хасагдсны улмаас 23 нэгжээр өр, авлагын судалгаа нэгтгэн гаргаж Тамгын газрын даргад танилцуулж ажилласан.

10.1.Санхүүгийн аудитын дүгнэлтийн талаар:

- Үндэсний аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орсон аудитаар 23 нэгж “Зөрчилгүй”, 1 нэгж “Хязгаарлалттай”, 24 нэгжийн төвлөрүүлэн захирагч тайлан “Хязгаарлалттай” дүгнэгдсэн. 23 нэгжийн 2023 оны санхүүгийн

тайлангийн аудитаар 4,3 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий акт 3, 43,9 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий албан шаардлага 7, 150,4 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий зөвлөмж 17, нийт мөнгөн дүнгээр 198,6 сая төгрөгийн зөрчил илэрч, нэгжүүд аудитаас тогтоосон хугацаанд биелэлтээ хүргүүлэхээр ажиллаж байна.

- Төрийн үнэт цаас хэвлэл ХХК нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 47,3 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий акт 2, 118,9 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий албан шаардлага 2, 35.642,4 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий зөвлөмж 8, нийт мөнгөн дүнгээр 35.808,7 сая төгрөгийн зөрчил илэрч, нэгж нь аудитаас тогтоосон хугацаанд биелэлтээ хүргүүлэхээр ажиллаж байна.
- 2023 оны санхүүгийн тайланд орсон аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, арга хэмжээний төлөвлөгөөг гарган 2024 оны 04 сарын 04-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлэн, биелэлтийг ханган ажиллаж байна.
- Үндэсний аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орсон аудитын биелэлтийг 2024 оны 05 сарын 31-ны байдлаарх гарган нийт 9 зөрчлийг 97,8 хувиар биелүүлж тайлагнаж, хүргүүлж ажилласан.
- Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 1/2 тоот албан даалгаварын дагуу төлөвлөгөөний биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 сарын 28-ны өдрийн 1/7213 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.

10.2.Төрийн өмч болох үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн 45 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд баригдсан Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 5,064,9 сая төгрөгийн үнэтэй барилгыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсөн.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд баригдсан Хэнтий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2,514,1 сая төгрөгийн үнэтэй барилгыг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсөн.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 05 сарын 16-ний өдрийн 234 дугаар тогтоолоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй 43 нэр төрлийн 16,115.1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-ны төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-д шилжүүлсэн тогтоол гарсан.
- Мөн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хөрөнгө бүртгэх, дахин үнэлэх, акталж данснаас хасах шийдвэр гаргуулах тухай Өмнөговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/2288 тоот захирамжаар нийлүүлэгдсэн 68,7 сая төгрөгийн үнэтэй хөрөнгүүдийг санхүүгийн тайланд бүртгэлд тусгах, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Булган, Өмнөговь, Говь-Алтай, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дансанд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дууссан цаашид ашиглах боломжтой, ашиглагдаж байгаа 261 ширхэг хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон үнээр санхүүгийн тайланд бүртгэх, Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн тайланд бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанартай нийт 12,2 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, Говь-Алтай, Булган, Өмнөговь, Төв аймгийн Улсын бүртгэлийн санхүүгийн тайланд эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн, эвдэрч ашиглах боломжгүй болсон 134,0 сая төгрөгийн үнэтэй эргэлтийн бус хөрөнгийг акталж данснаас хасах талаар хүсэлтийг тус тус

2024 оны 2024 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн 1/6398 тоот хүсэлтийг ХЗДХЯ-нд хүргүүлж ажилласан.

10.3.Төлөвлөгөөнд тусаагүй ажлын талаар:

- Засгийн газрын 2024 оны 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор төрийн албан хаагчийн цалинг шинэчилэхэд орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох, Засгийн газрын 2024 оны 82 дугаар “Төрийн захиргааны, үйлчилгээний төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг хэрэгжүүлэн тус байгууллагын аймгийн нэгжид 697, алслагдсан 3 дүүрэгт 33, нийт 730 албан хаагчдад орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын нэмэгдлийг нэмж 20 хувиар олгох, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолыг хэрэгжүүлж гүйцэтгэлийн төлөвлөгөөний мөнгөн урамшуулал олгоход 1.247 төрийн албан хаагчдын мөнгөн урамшууллыг жилд 1 удаа дунджаар үндсэн цалингийн 25 хүртэлх хувиар олгохоор тооцоход цалингийн сангийн дутагдлын тооцоог боловсруулан танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 04 сарын 18-ны өдрийн 1/5068 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Мөн яаманд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор олгоход үүсч байгаа дутагдсан 644,0 сая төгрөг, 2024 оны 82 дугаар дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг нэмэхэд 1.592,8 сая төгрөг, 2024 оны 83 дугаар тогтоолоор 5 жил тутам ажиллаж байгаа албан хаагчдийн тэтгэмжид 3.634,4 сая төгрөг буюу нийт 5.871,2 сая төгрөгийн асуудлыг 2024 оны 05 сарын 15-ны өдрийн 1/6546 дугаар албан бичгээр хандан, Сангийн яамнаас албан ёсоор чиглэл авч ажиллаж байна.

10.4.Эргэлтийн хөрөнгө болох бараа материал, үнэт цаас ашиглалтын талаар:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/707 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягыг хүлээн авах, олгох, зарцуулалтад хяналт тавих журам”-д заасны дагуу нийслэл, аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн сар бүр ирүүлсэн үнэт цаас, маягтын тайланг нэгтгэн, удирдлагад танилцуулж ажилласан.
- УБЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 20-ны А/1719 тоот тушаалын Ажлын хэсэг 2023 оны бүтэн жилийн үнэт цаас, маягтын хариуцсан няравын үлдэгдэл болон газар хэлтсийн улсын бүртгэгч нарын гар дээр байгаа үнэт цаас, маягыг тоолж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулсан бөгөөд тооллогын үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.Сар бүрийн эцэст агуулахын дэвтрийн үлдэгдлийг хариуцсан нягтлан бодогч нар тулган баталгаажуулан ажиллаж байна.
- Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д 2023 оны 7 сарын 1 нээс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хүчингүй болсон үнэт цаас, маягыг акталж, устгах талаарх танилцуулгыг оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.
- үйлчилгээний төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг хэрэгжүүлэн тус байгууллагын аймгийн нэгжид 697, алслагдсан 3 дүүрэгт 33, нийт 730 албан хаагчдад орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын нэмэгдлийг нэмж 20 хувиар олгох, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолыг хэрэгжүүлж гүйцэтгэлийн төлөвлөгөөний мөнгөн урамшуулал олгоход 1.247 төрийн албан хаагчдын мөнгөн урамшууллыг жилд 1 удаа дунджаар үндсэн цалингийн 25 хүртэлх хувиар олгохоор тооцоход цалингийн сангийн дутагдлын тооцоог боловсруулан танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 04 сарын 18-ны өдрийн 1/5068 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Мөн яаманд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор олгоход үүсч байгаа дутагдсан 644,0 сая төгрөг, 2024 оны 82 дугаар дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг нэмэхэд 1.592,8 сая төгрөг, 2024 оны 83 дугаар тогтоолоор 5 жил тутам

ажиллаж байгаа албан хаагчдийн тэтгэмжид 3.634,4 сая төгрөг буюу нийт 5.871,2 сая төгрөгийн асуудлыг 2024 оны 05 сарын 15-ны өдрийн 1/6546 дугаар албан бичгээр хандан, Сангийн яамнаас албан ёсоор чиглэл авч ажиллаж байна.

10.5.Эргэлтийн хөрөнгө болох бараа материал, үнэт цаас ашиглалтын талаар:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/707 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягтыг хүлээн авах, олгох, зарцуулалтад хяналт тавих журам”-д заасны дагуу нийслэл, аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн сар бүр ирүүлсэн үнэт цаас, маягтын тайланг нэгтгэн, удирдлагад танилцуулж ажилласан.
- УБЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 20-ны А/1719 тоот тушаалын Ажлын хэсэг 2023 оны бүтэн жилийн үнэт цаас, маягтын хариуцсан няравын үлдэгдэл болон газар хэлтсийн улсын бүртгэгч нарын гар дээр байгаа үнэт цаас, маягтыг тоолж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулсан бөгөөд тооллогын үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.Сар бүрийн эцэст агуулахын дэвтрийн үлдэгдлийг хариуцсан нягтлан бодогч нар тулган баталгаажуулан ажиллаж байна.
- Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д 2023 оны 7 сарын 1 нээс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хүчингүй болсон үнэт цаас, маягтыг акталж, устгах талаарх танилцуулгыг оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

10.6.Худалдан авах ажиллагааны талаар:

10.6.1.Хөрөнгө оруулалт /нээлттэй/

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын тоног төхөөрөмж болох 3,750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны худалдан авалтын нээлттэй тендерийг 2024.01.18-ны өдөр зарлан, зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан “Смарт карт” ХХК-тай 2024/34 тоот гэрээ байгуулж, гэрээний дагуу тоног төхөөрөмжийг УБЕГ-ын даргын 2024.04.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан. Гэрээний гүйцэтгэл 100%.
- Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн байрны их засвар /Баянхонгор аймаг баянхонгор сум/-ын ажил нь 911.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд тухайн нээлттэй тендерийг 2024.02.02-ны өдөр зарлан, зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан “Өгөөмөр уул” ХХК-тай ХЗДХЯ/20240101023, 24 тоот гэрээ байгуулж, гэрээний дагуу барилгын их засварийн ажил урьдчилгаа санхүүжилт авахгүйгээр хэвийн явагдаж байна. . Гэрээний гүйцэтгэл 40%-тай байна.
- Улсын бүртгэлийн хэлтэс, архивын хэлтсийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/-ын ажил нь 5,069.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд тухайн барилга барих газрыг чөлөөлөх ажил хийгдэж байгаатай холбогдуулан нээлттэй тендер зохион байгуулах үйл ажиллагаа хүлээлтийн байдалтай байна.

10.6.2.Урсгал зардлаас /нээлттэй/

- Батлагдсан 32,802.0 сая төгрөгийн төсөвтэй 11 төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллагатай 32,289.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус газраас зарлагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчил байхгүй.
- “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх багц 1-Гэрчилгээ нийлүүлэх” 192,0 сая төгрөгийн Үндэсний үнэт цаас” ХХК-ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан мэдэгдэл хүргүүлж, хуулийн хугацаанд гомдол гараагүй тул 2024/18, SP24006 тоот гэрээ

байгуулж, гэрээний хуваарийн дагуу нийлүүлсэн гэрчилгээ, маягтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд гэрээний хэрэгжилт 100% биелсэн.

- “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх Багц 2-Бүртгэлийн маягт нийлүүлэх тендер”-ийн “Үндэсний үнэт цаас” ХХК-ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан мэдэгдэл хүргүүлж, хуулийн хугацаанд гомдол гараагүй тул 2024/19, SP24007 тоот гэрээ байгуулж, гэрээний хуваарийн дагуу нийлүүлсэн гэрчилгээ, маягтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд гэрээний хэрэгжилт 100% биелсэн.
- “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх багц 3-Гэрчилгээний хавтас нийлүүлэх” 137,5 сая төгрөгийн 2024/20, 2024/0313/02 тоот гэрээг “Соёмбо принтинг” ХХК-тай байгуулж, гэрээний хуваарийн дагуу нийлүүлэх гэрчилгээний хавтсыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд гэрээний хэрэгжилт 100% биелсэн.
- “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх багц 4-Архивын хувийн хэргийн хавтас, бүртгэлийн дэвтэр хэвлэн нийлүүлэх” 80,9 сая төгрөгийн 2024/22 тоот гэрээг “Адмон принт” ХХК -тай байгуулж, гэрээний хуваарийн дагуу нийлүүлэх хавтас, дэвтрийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд гэрээний хэрэгжилт 100% биелсэн.
- “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх Багц 5- Архивын хайрцаган хавтас нийлүүлэх тендер”-ийн “Соёмбо принтинг” ХХК-ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1-дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан мэдэгдэл хүргүүлж, хуулийн хугацаанд гомдол гараагүй тул 2024/21, 2024/0313/01 тоот гэрээ ажлын хэсгийн гишүүд акт үйлдэж, хүлээн авсан болно. Гэрээний гүйцэтгэл 100% биелсэн.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бичиг хэрэгсэл нийлүүлэх тендерийн Багц 1- Бичгийн цаас нийлүүлэх тендер “Грийт пийк” ХХК-тай “Бичиг хэргийн материал нийлүүлэх тендерийн Багц 1- Бичгийн цаас нийлүүлэх тендер”-ийн УБЕГ/2024012004 Багц-1, 2024/23 тоот гэрээ байгуулж, тус гэрээний дагуу нийлүүлэх бичгийн цаасыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд гэрээний хэрэгжилт 100% биелсэн.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бичиг хэрэгсэл нийлүүлэх тендерийн Багц 2- Принтерийн хор нийлүүлэх тендер”-т шалгарсан “Алтанзуун” ХХК-тай УБЕГ/20240102004 Багц-2, 2024/36 тоот гэрээ байгуулж, тус гэрээний дагуу нийлүүлэх принтерийн хорыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны удирдамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд акт үйлдэж, хүлээн аван ажиллаж байна.
- Улсын бүртгэлийн үйлчлэгээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник хэрэгсэл, техникийн үйлчилгээ, лиценз худалдан авах ажиллагааг явуулж шалгарсан “Саммит компьютер технологи” ХХК-тай “Улсын бүртгэлийн техник хэрэгсэл, техникийн үйлчилгээ, лиценз худалдан авах тендер”-ийн 2024/22 тоот гэрээ байгуулж, тус гэрээний дагуу нийлүүлсэн барааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024.03.11-ний өдрийн А/36 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан. Гэрээний гүйцэтгэл 100% хүлээлгэж өгсөн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Шатахуун нийлүүлэх тендерт шалгарсан “Шунхлайтрейдинг” ХХК-тай 14,0 сая төгрөгийн Т/47, 2024/06 тоот гэрээ байгуулж, гэрээний дагуу шатахуун хүлээн авч, ажиллаж байна. Гэрээний хэрэгжилт 50%-тай байна.
- Архивын ерөнхий газартай “Албан бичгийн хэвлэмэл хуудас нийлүүлэх” 2024 оны 2024/18 тоот гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу дүгнэлт, албан бланкыг хүлээн авч ажиллаж байна. Гэрээний гүйцэтгэл 100%.
- Худалдан авах ажиллагааны 2024 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сонгогчийн ирцийг бүртгэх программ хангамж боловсруулахаар “Аствишн” ХХК-тай Н-2024/09 тоот шууд гэрээ байгуулж, гэрээний нийлүүлэлтийн хуваарийн дагуу УБЕГ-ын даргын 2024.03.04-ний өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Сонгогчдын бүртгэлтэй холбоотой программ хангамжийг хүлээн авч, ажиллаж байна. Гэрээний гүйцэтгэл 100%
- Худалдан авах ажиллагааны 2024 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Метадата" ХХК-тай Н-2024/10 тоот шууд гэрээ байгуулж, гэрээний нийлүүлэлтийн хуваарийн дагуу УБЕГ-ын даргын 2024.03.04-ний өдрийн А/31 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Битүүмжлэх лац бусад барааг хүлээн авч, ажилласан. Гэрээний гүйцэтгэл 100% хүлээлгэж өгсөн.
- 2024 оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллааны биелэлт 95,8 хувьтай байна.
- Худалдан авалтын тендерээр нийлүүлж байгаа үнэт цаас, маягтын загвар батлуулах тухай 2024 оны 03 сарын 26-ны өдрийн 243, 244, 245, 242, 241 тоот дотоод албан бичгийн төслийг боловсруулан, удирдлагаар батлуулж, газруудад хүргүүлж, загварыг баталгаажуулж ажилласан.
- Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгууллагын худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг 2024. Оны 04 сарын 16-ны өдрийн 1/4859 тоот албан бичгийн төслийг боловсруулан, удирдлагаар батлуулж, хүргүүлсэн.

10.7.Төсвийн төлөвлөлт, түүнд өөрчлөлт оруулах ажлын хүрээнд

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг 2024 оны 03 сарын 28-ны өдөр цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж ажилласан.
- Байгууллагын 2025 оны урсгал төсвийн төсөлд тусгах саналыг авахаар Улсын бүртгэлийн төв архив, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар, Мэдээллийн технологийн газарт 2025 оны 05 сарын 27-ны өдрийн 415,416 дугаар дотоод албан бичгээр хүргүүлж ажиллаж, тусгах саналууд тус тус газруудаас ирснийг хязгаарын саналд тусгаж ажилласан.
- Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгууллагын 2025 оны төсвийн хязгаарын саналыг 2024 оын 05 дугаар сарын 31-ны өдрийн 1/7450 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж ажилласан.
- Мөн уг ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын ажлыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим системд шивж ажилласан.
- Хүрэлцэхгүй байгаа зардлыг хооронд шилжүүлэх, өргүй ажиллах үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчид сар бүрийн төсвийн хуваарийн өөрчлөлтийн саналыг сарын

бүрийн 20-ны дотор боловсруулан хүргүүлж, төсвийн зарцуулалтыг цахим программд шивж ажиллаж байна.

10.8.УИХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн талаар:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд тус байгууллагын хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхээр улсын төсөвт батлагдсан 3,039,0 сая төгрөгийг зарцуулах зардлын төсвийг даргын 2024 оны А/24 тоот тушаалаар баталж санхүүжилтыг олгож ажиллаж байна.
- Сонгуулийн үйл ажиллагааны зардлыг улсын бүртгэлийн болон итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардалд төсвийн 55,3 хувь, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардалд төсвийн 4,8 хувь, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл, программ хангамж худалдан авах зардалд төсвийн 18,7 хувь, сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардалд төсвийн 10,9 хувь, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх, тухайн өдөр хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд төсвийн 5,8 хувь, сонгууль зохион байгуулахтай холбогдсон мэдээлэл, сурталчилгааны зардалд төсвийн 0,7 хувь, сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардалд төсвийн 3,9 хувийг тус тус зарцуулахаар тооцоолол хийж ажилласан.
- Сонгууль зохион байгуулах 2.196 хэсгийн хороонд 1.865 ширхэг бүртгэлийн техник хэрэгсэл /иж бүрдэлд зөөврийн компьютер, хурууны хээ уншигч, камер, уртасгагч/, мөн тооны ирц хэвлэх принтер, принтерийн хор, принтерийн цаас, битүүмжлэх лац, кабель зэргийг хуваарилан олгохоор бэлтгэж 2024 оны 06 сарын 12-ны өдрөөс эхэлсэн.

10.9.Ахмад настны болон хүүхэд хамгааллын чиглэлээр:

- Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны цагаан сараар УБЕГ-ын 130 ахмад ажилтанд мэндчилгээ хүргүүлж, хүндэтгэл үзүүлж ажилласан.

Хүүхдийн өрөөг тохижуулан 2023 оны 11 дүгээр сараас өнөөдрийг хүртэл давхардсан тоогоор 50-60 хүүхэд өрөөнд ирж чөлөөт цагаа өнгөрүүлсэн.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” чиглэлээр 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан, сарын аяны хүрээнд хийсэн ажлын биелэлтийг ХЗДХЯ-нд 05 дугаар сарын 08-нд 2/5998 тоотой хүргүүлсэн.

10.10.Бусад ажлын чиглэлээр:

- Байгууллагын эзэмших эрхтэй гаражийн газрыг 2 хувааж АӨСҮТ-д шилжүүлэх ажлын хүрээнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, Газрын төлөв байдлын судалгааг мэргэжлийн “Говь-Эко” ХХК-р хийлгэн ажлыг гүйцэтгэлийг хүлээн авсан.
- Юнител ХХК-тай байгуулсан гэрээг шинэчилж, 2024 оны 04 сарын 01-ны өдрөөс аймаг, төвийн 6 дүүргийн интернетийн хурдыг 10mgb, захын 3 дүүргийн интернетийн хурдыг 6mgb болгох, нэмэлтээр 20 сумыг тус компанийн зардлаар үндсэн төхөөрөмжийг суурилуулж, хамтран ажилах гэрээг байгуулан ажиллаж байна.

10.11.Аж ахуйн ажлын талаар:

- Байгууллагын 2 байрны бүх өрөө тасалгаа, коридор, агуулах, гаражид шавьж устгал, ариутгал 2024 оны 05 сарын 03-ны өдөр хийлгэсэн.
- Байгууллагын 9 автомашинд Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цэнхэр дугаартай болгох ажлыг зохион байгуулж 04 дүгээр сард дугаараа авсан.

- Цайны газрыг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж гэрээний төсөл, хүсэлтийг ТӨБЗГ-д хүргүүлж, “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г 2024 оны 04 сарын 17-ны өдөр ХЗДХЯ-2024/05 тоот гурвалсан гэрээг 2024 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд байгуулсан.
- Байгууллагын гаражийн газрыг 2 хувааж АӨСҮТ-д шилжүүлэх ажлын бэлтгэл ажлыг хийж дуусгасан. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрын төлөв байдлын судалгааг “Говь-Эко” ХХК-иар хийж гүйцэтгүүлэн ажлыг гүйцэтгэлийг хүлээн авсан. 2 байгууллагын газрыг шилжүүлэн гэрчилгээг шинэчлэх тухай албан бичгийг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 2/6106 тоотоор газрын албанд хүргүүлсэн.
- Хан Уул дүүрэгт байрлалтай байгууллагын 1 га газрын гэрээ, гэрчилгээний хугацаа дууссан тул шинэчлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- Байгууллагын гадна орчны тохижилт, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024 оны 05-06 сард гадна, дотор хийх засвар үйлчилгээний жагсаалт гарган, төсвийг батлуулан холбогдох ажлуудыг хийж байна.,
- Төв байрны харуул хамгаалалт, байгууллагын аюулгүй хэвийн ажиллагааг хангах зорилгоор “орох гарах” нүүр уншигч, картаар нэвтрэх гарц байршуулсан. Зүүн талын автомашины зогсоолын хаалтыг автомашины дугаар танигч хаалт шинээр хийлгэж албан хаагчдын автомашиныг байрлуулж хэвшүүлээд байна.
- Сонгуулийн тоног төхөөрөмжийг хүлээн авч хайрцаглах ажлыг зохион байгуулахад үйлчилгээний 12 албан хаагч хаягдал картонон хайрцаг, хогыг хог тээвэрт ачуулах ажлыг 1 дүгээр сард ажлын 8 хоног хийж гүйцэтгэсэн
- С1 гаражийн хойд талаар 27 метр урт, 120 см өндөртэй төмөр хайс, төв байрны зүүн талын явган хүний чулуун зам дээр гадны автомашинууд гарч зогсон замыг эвдлэх явдлыг таслан зогсоож, 3 ширхэг хайс тус тус хийж, 15 ширхэг буйлс, 50 ширхэг шар хуайс, 10 ширхэг бургас мод байгууллагын эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайд тарьж, 200 м2 орчим газрыг зүлэгжүүлэн цэцгийн мандалт 800 ширхэг мандлын цэцэг суулгах ажлыг хийсэн.
- 4 дүгээр сарын 10-наас 16-ны өдрүүдэд байгууллагын гадна их цэвэрлэгээг хийж нийтийн эзэмшил, зам талбай орчны 50 м2 хүртэлх газрыг цэвэрлэж, байгууллагын байрны гадна фасад, шатыг хөөсөн цэвэрлэгээ хийсэн. Төв байр болон 2 дугаар байрны нийт 5 дээвэр, үүдний 3 гонхны дээврийн цас мөсийг цэвэрлэх ажлыг ажлын 3 өдөрт бүрэн, В1 гаражийн бохирын худгийн лагыг 2 удаа цэвэрлүүлсэн. Гаражийн мотрыг задлаж цэвэрлэн засуулах ажлыг 6 дугаар сард хийнэ. Фитнесийн өрөөний гүйлтийн замыг засварчин дуудаж үзүүлж хуучин замыг эвдэрсэн сэлбэгийг захиалсан, С1 талбайн ил зогсоол руу өгсөх, уруудах шат хальтиргаатай явган хүн гэмтэх аюулаас сэргийлэх зорилгоор шатны ханыг дагуулах төмөр трубаг гагнан бариул шинээр хийлгэсэн, 2 дугаар байрны дээвэр дээр байгаа цахилгаан, холбооны утсыг цэгцлэх, хэрэгцээгүй утсыг салгаж хаях ажлыг зохион байгуулсан.
- УБНАГ-ын архивын фондны агаар сэлгэлт, чийгжүүлэлт шаардлага хангахгүй байгаа тул сайжруулах зорилгоор хүйтнээр үлээгч, чийгшүүлэгч уур гаргадаг сэнс 5 ширхэгийг фонд тус бүрт байршуулсан. 2 дугаар байрны тарьсан модруу албан хаагчдын автомашин тулж зогсон модны мөчрийг гэмтээхээс сэргийлж 16 зогсоолд төмөр трубагаар зам дээр хязгаарлагч гагнаж хийж талбайд байршуулж байна. Мөн тус байрны аваарын шат, узелийн өрөөг цэвэрлэж орох гарах аюулгүй нэвтрэх нөхцлийг бүрдүүлэн шатыг төмрийн будгаар будан, 2, 4 давхрын шатны шилэн хаалганд цоож түгжээ хийн цагдаа жижүүр дээр түлхүүрийг хүлээлцэн ажиллаж хэвшээд байна. 2 дугаар байрны 410 тоот өрөөний хана эмульдэх, тааз солих,

таазанд хөөс цацаж дусаал гоожихоос сэргийлэх, өрөөг тохижуулах ажлыг 6 дугаар сард хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

АРВАННЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД

11.1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний 20-д заасны дагуу 21 аймаг, 9 дүүргийн 2024 онд хийгдсэн 24549 шилжилт хөдөлгөөний бүртгэлийг шалган, шалгалтаар нийт 1113 зөрчил илэрснээс цахим санд баталгаажуулаагүй 39, нотлох баримт цахимжуулаагүй 999, хуульд заасан нотлох баримтгүй, ИУБ-22 маягтад бүртгүүлсэн иргэний гарын үсэг зурагдаагүй 75 зөрчил илэрснийг хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 21 дүгээр албан шаардлагыг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулж, улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцүүлсэн.

11.2. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/ системийн 4.0 шинэ хувилбар нэвтрэхтэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

-Иргэний шилжилт хөдөлгөөний үйлчилгээний нэмэлт хөгжүүлэлтийн ажлын хүрээнд бусдын хаяг дээр шилжин очих гэж байгаа тохиолдолд 2 сонголттой болгосон. Цахимаар зөвшөөрөл хүсэх, файлаар хүсэлтээ илгээх боломжтой болгож хөгжүүллээ.

-Иргэний шилжилт хөдөлгөөний хүсэлтийг ганц удаа илгээх боломжтой болгох хөгжүүлэлтийг хийв.

-Манай байгууллагаас үзүүлж байгаа 2 шатлалт үйлчилгээнүүдийг e-mongolia апп-руу оруулах, дахин загварчлах хөгжүүлэлтийн хүрээнд цахим хэлбэрээр баталгаажуулалт авах, мөн гарын үсгийн зуруулж үр дүнг шийдвэрлэх ажилтан руу илгээгдэхээр болгох, алхмын хувьд шаардлагагүй илүү алхмыг хасуулж, шаардлагатай талбаруудаа шууд сервис дуудаж талбарыг системээс бөглөгдөхөөр болгож мөн гадаад паспортын зургийг хавсаргахыг болиулж иргэний бүртгэлийн систем руу шууд илгээгдэхээр /photo.burtgel.gov.mn/ API холбож зургийг харуулах нэмэлт хөгжүүлэлтийг хамтран хөгжүүллээ.

-Мэдэгдэл хүргэх системийн хувьд Иргэний үнэмлэхийн хугацаа дуусах дөхсөн тохиолдолд мэдэгдэл хүргэх, гадаад паспортын хугацаа дуусах дөхсөн тохиолдолд мэдэгдэл хүргэх сервисүүдийг гаргаж өгөв.

-Бичиг баримтын хэсэгт харуулах гадаад паспортын нүүрэн дэх мэдээллийг харуулах сервисийг гарган өгөв.

-EKids хүүхэд хамгааллын системийн ажлын хүрээнд хүүхдийн мэдээлэл эцэг/эхээр нь дуудаж харуулах боломжтой сервисийг гарган өгөв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын баталсан удирдамжийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэгт заасны дагуу гадаад улсад амьдарч байгаа иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгуульд оролцох эрхийг хангах, санал өгөх боломжийг бүрдүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор иргэний улсын бүртгэлийн оффлайн системийг нууцлал бүхий сүлжээ /VPN/-д холбох, иргэний улсын бүртгэлийн ажилтны улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд дэмжин туслах, чадавхжуулах, иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай танилцах, хянах, бүртгэл хариуцсан ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээлэл солилцох болон гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор 2024 оны 5 дугаар сарын 11 өдрөөс эхлэн 29 чиглэлд 37 Дипломат төлөөлөгчийн газрыг Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбосон.

11.3. Монгол Улсын Их хурлын Хянан шалгах түр хорооноос ирүүлсэн 602 иргэнд холбогдох мэдээллийг шалгаж, 7905 иргэний төрөл садангийн мэдээлэл, тэдгээрийн хуулийн этгээдийн лавлагааг, “Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт, шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хороонд 90 хуулийн этгээдийн 207 лавлагаа, 20 иргэнд холбогдох 204 лавлагаа, 117 мэдээллийг, “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр

олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хороонд 1772 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг тус тус хүргүүлсэн.

11.4. Улсын бүртгэлийн ерөнхий газарт хадгалдагдаж буй Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалалт хамгаалалтыг сайжруулж, тус газарт ирсэн 39, явсан 49 нууцад хамаарах албан бичгийг хүлээн авч бүртгэн, холбогдох нэгж албан тушаалтанд шилжүүлсэн. Шинээр томилогдсон 1 нууц хамгаалах ажилтныг аюулгүй байдлын шалгалтад хамруулж, нууц хамгаалах ажилтнаар томилуулсан. Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий 22 албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах" журмын хүрээнд 2223 албан хаагчаас төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажилласан. Тагнуулын байгууллагатай мэдээлэл солилцож, холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл чиглэлээ авч ажиллаж байна. Шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн 13 албан хаагчаас албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажилласан.

---oOo---

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР